



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
 -
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
 ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 158

Алтай хот

┌ Ажлын хэсэг байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Автотээврийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.6 дахь заалт, Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үйлчилгээ, засвар хийх журмын 1 дүгээр зүйлийн 1.5 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 291 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн авто үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд ангилал тогтоох, тохирлын гэрчилгээ олгох ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ажлагч: Г.Хурцгэрэл - (Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд:

Н.Алтанбагана - (Мэргэжлийн хяналтын газрын автотээврийн хяналтын улсын байцаагч)

Х.Мягмарсүрэн - (Мэргэжлийн хяналтын газрын хэмжил зүйн хяналтын улсын байцаагч)

Г.Билэгсайхан - (Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Ц.Амарсанаа - (Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)

Б.Жавзмаа - (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын орчны бохирдол, хог хаягдал, химийн хорт бодисын асуудал хариуцсан мэргэжилтэн)

П.Ууганбаатар - (Цагдаагийн газрын экологийн асуудал хариуцсан эрүүгийн ахлах цагдаагийн ахмад)

2.

- Д.Бат-Эрхэм -(Автотээврийн төвийн автотээврийн хяналтын улсын байцаагч)
Л.Батгэрэл -(Автотээврийн төвийн автотээврийн хяналтын улсын байцаагч)
Т.Мөнхнасан -(Стандарт, хэмжилзүйн хэлтсийн дарга)
Ю.Чинзориг -(Иргэний төлөөлөл)
(зөвшилцсөнөөр)

Нарийн бичгийн дарга:З.Жаргалтуяа -(Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

2.Үзлэг шалгалтыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу явуулан аттестатчилах, тохирлын гэрчилгээ олгох арга хэмжээг авч ажиллан, дүнг танилцуулахыг ажлын хэсэг (Г.Хурцгэрэл)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2021 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/526 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ